



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№26 /470/

2023.02.06

Цаг үе, үйл явдал

НЭГДМЭЛ ЭХ СУРВАЛЖТАЙ, НЭГ АЛСЫН ХАРААТАЙ БАЙХ НЬ ЧУХЛЫГ ОНЦОЛЛОО

Өнөөдөр БХЯ-ны харьяа хэвлэл мэдээлэл, соёл урлагийн байгууллагуудын төлөөлөл хуралдаж Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг нэгдмэл цогц удирдлага зохион байгуулалтаар хэрхэн шинэлэг байдлаар иргэд, олон нийтэд сурталчлах талаар санал солилцлоо.

Хурлын үеэр цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг товч танилцуулж, нэн тэргүүнд анхаарч ажиллах шаардлагатай зарим асуудлыг тодорхойллоо.

Тухайлбал, мэдээллийн хурдныг сайжруулж, хамрах хүрээг өргөтгөх, салбарын хэмжээнд зохиогдохоор төлөвлөгдсөн үйл ажиллагааны календарчилсан



Төлөвлөгөөг гаргаж, нэгдмэл шаардлагатай гэсэн дүгнэлтэд зохион байгуулалттайгаар хамтран хүрлээ. Уг хурлыг жил бүр уламжлал ажиллах талаар онцгой анхаарах

болгон зохион байгуулах бөгөөд үйл ажиллагааг нь улам төгөлдөржүүлэх зорилгоор орон тооны бус зөвлөлийг байгуулах саналтай байгаагаа зарим байгууллагын дарга нар илэрхийллээ.

Хэвлэл мэдээлэл, соёл урлагийн байгууллагууд мэдээ мэдээллийн нэгдмэл эх сурвалжтай, нэг алсын хараатайгаар үйл ажиллагаа явуулах нь ажил үүргийн хуваарилалт болон харилцан ойлголцол, цаашлаад уран бүтээлийн чанарыг дээшлүүлэх, мэдээллийг иргэдэд хүргэх талаар онцгой ач холбогдол үзүүлнэ гэдгийг хуралд оролцогчид хэлж байсан юм.

Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,511	3,515
EUR	3,795	3,820
CNY	517	520
RUB	48	48.50
JPY	26.80	27.20
KRW	2.82	2.85

ЗУРХАЙ



2023.02.06 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 16

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

08.13-17.59

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олдох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

БАЙЛДАГЧ Б.ТӨМӨРБАТ: ЦЭРГИЙН АЛБА ХААХ НЬ МИНИЙ ЗӨВ СОНГОЛТ ЮМ



Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид ТВ8 телевизийн уран бүтээлчидтэй хамтран ажиллах үеэр байлдагч Б.Төмөрбаттай уулзаж ярилцав. Тэрээр өөрийн хүсэлтээр цэргийн албанд татагдан ирж, захирагч, дарга нараас их зүйлийг сурч байгаагийн зэрэгцээ цаг баримтлах, харилцаа, хандлагаа өөрчлөх тал дээр ахиц гаргаж чадсан гэдгээ нотолж чадна хэмээсэн юм. Энэ өдөр тус ангийн Цэргийн гал тогоогоор ороход "Сонголттой хоолны өдөр" байсан бөгөөд тогооч мэргэжлийг эзэмшин, энэхүү мэргэжлийнхээ дагуу ажиллаж байсан цэргийн алба хаагчийг сонгож ихэд олзуурхсан юм.

Байлдагч Ц.Төмөрбат цааш нь ярихдаа: "Би Нийслэлийн Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийг төгсөөд Нийгэм, сэтгэл судлалын дээд

сургуульд сэтгэл зүйчээр суралцаж байлаа. Энэ хугацаанд богино хугацааны сургалтад давхар хамрагдан, тогооч мэргэжлийг эзэмшсэн.

Ингээд чөлөөт цагаар Япон хоолны газар туслах тогоочоор ажиллаж байсан. Миний хувьд Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлэхийг эрхэм болгон хугацаат цэргийн алба хааж буйдаа сэтгэгдэл маш өндөр байгаа. Цэргийн албанд ирээд эр бие хатуужиж, бие бялдар-сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй болж байгаагийн зэрэгцээ өдөр тутмын цагийн хуваарьт ажиллагаанд жигд хамрагдаж, олон найз нөхөдтэй болсондоо баяртай байна. Би тогооч мэргэжлийг эзэмшиж, энэ мэргэжлийнхээ дагуу олон сар ажилласныхаа үр дүнд их зүйлийг сурч дадлагажиж байна. Тиймээс тусангийн тогоочнарынур чадварыг өндөрөөр үнэлдэг. Бидэнд амт чанар сайтай, хүртээмжтэй, илчлэг сайтай халуун хоолоор өдөр тутам үйлчилж байдаг тогооч, бэлтгэгч, ажилтнууддаа их баярлалаа гэдгээ үеийн нөхдөө төлөөлж бахархал дүүрэн илэрхийлье. Манай ангийн

цэргийн гал тогоо нь сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдож, бүрэн засвар хийгдсэнийг нь мэдэрсэн. Тэрчлэн өнгөрсөн хугацаанд цэргийн хэрэгт шамдан суралцахын зэрэгцээ амралт, чөлөөт цагуудаар лекц, мэдээлэл, соёл олон нийтийн ажлуудад идэвхтэй хамрагдаж, олон төрлийн уралдаан, тэмцээнд амжилттай оролцлоо. Эдгээрээс манай ротын хугацаат цэргийн алба хаагчид олс таталтын болон гар бөмбөгийн тэмцээнд тэргүүн байрт шалгарсан юм. Цаашид албаа нэр төртэйгөөр хааж, үе тэнгийнхйгээ манлайлах болно" гэдгээ онцолсон юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



"АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ӨДӨР"-ӨӨР...



Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн 2022-2023 оны цэргийн сургалт, бэлтгэл, сэтгэл зүйн төлөвлөгөөний дагуу "Баасан" гараг бүрийг ажилтан алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх өдөр болгосон билээ. Үүнтэй холбогдуулан 2 дугаар сарын 03-ны өдөр гар нийлэмжтэй ажиллагааг нэмэгдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Хөгжөөнт буухиа" тэмцээнийг явуулав.

Тэмцээний тэргүүн байрт Я.Нямдорж ахлагчтай "Баатархайрхан", дэд байрт П.Ням-Осор ахлагчтай "Буянт гол", гутгаар байрт Б.Отгонжаргал ахлагчтай "Жаргалант хайрхан" багууд шалгарч хамт олноо манлайлсан юм.

Ахмад Н.ЭРДЭНЭЧИМЭГ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 676,264,168

Эдгэрсэн

Нийт: 648,701,708

Нас барсан

Нийт: 6,772,226

АХЛАХ АХЛАГЧ Н.БАЯСГАЛАН: 26 ЖИЛ БӨМБӨРТЭЙ НӨХӨРЛӨЖ БАЙНА, ХАМГИЙН ГОЁ ЗЭМСЭГ



Аливаа цэргийн ёслолын арга хэмжээг дайчин хэмнэлт эгшиг аялгуу үгүйгээр төсөөлшгүй. Тэр дундаа бүрээ бөмбөрийн сүрт нижигнээнгүйгээр. Цэрэг дайчдын эрэмгий чанар, эрч хүчийг харуулсан үйл ажиллагаа, эрмэг залуухан цэргүүдийн алхаа, яруу алдрыг бахдан дуулсан цэрэг эрсийн дуу бүрийн ард цэргийн хөгжимчид бат зогсож байдаг юм. Цэргийн хөгжимчдийн төлөөлөл болгож энэ жил 100 жилийнхээ буурал түүхийг бичиж байгаа Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн бөмбөрчин, ахлах ахлагч Нямаагийн Баясгаланг онцолж байна.

Ахлах ахлагч Н.Баясгалан нь цэргийн хөгжимчний үүдийг Ерөнхий боловсролын сурагч байхаасаа л татаж, 30 жил цэргийн хөгжимний урлагт зүтгэж яваа залуу байна. Анх 1993 онд тухай үедээ хөгжимд сонирхолтой 5 сурагчийг Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийнхан шалгаруулж авсны нэг нь тэр бөгөөд хичээлдээ явангаа хөгжимд шамдан суралцдаг байж. Улмаар цэргийн хүн болох хүсэл мөрөөдлөө дагаж Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд 1997 онд хугацаат цэргийн алба хааж, үргэлжлүүлэн ахлагчийн албанд улирснаар бөмбөрчний гараагаа эхлүүлжээ.

Бөмбөрчин маань энэ хугацаанд 6-8 бөмбөрийг элэгдэлд оруулж “дуусгасан”, өөртөө сувинер болгон хадгалдаг мөн тооны бөмбөртэй гэнэ. Ямар л арга хэмжээ болно, тэр бүрт цэргийн хөгжимчдийнхөө хамт бөмбөрөө тэврээд очдог, 26 жил тэд бие биеэсээ огтхон ч холдоогүй “нөхөр” нь гэнэ. Зэвсэгт хүчний “Марш-тусгай бэлтгэлийн аварга” шалгаруулах тэмцээн бүрт дайчдынхаа сэтгэл санааг хөгжмийн цог жавхлантай аялгуугаар өргөж, Сүхбаатарын талбайд цэргийн ёслолын жагсаал болоход цэргийн хөгжимчдийнхөө дунд зогсож байдаг гээд олон жилийн түүхийг базаж онцлов.

Түүнийг бөмбөрчнөөс нь гадна цэрэг дайчдын хамтлаг гэдгээрээ алдартай “Оч”-оос салгаж ойлгох аргагүй. Анх “Оч” хамтлагийг 1977 онд “Чингис хаан” хамтлагийн ахлагч, Ардын жүжигчин Д.Жаргалсайхан Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд гурван жилийн алба хаахдаа байгуулж байсан түүхтэй. Байлдагч нараас бүрдсэн гэхэд аялгуут дуугаараа ард түмэндээ эчнээ танигдахын зэрэгцээ 1979 онд Болгарт болсон дууны тэмцээнд оролцож явсан хамтлаг. Ардын жүжигчин Д.Жаргалсайхан нарын цэргүүд халагдсаны дараа “Оч”-ыг хоёр дахь удаагаа залгамжлан уран бүтээл туурвисан байлдагч нь өнөөгийн “Цэцэг” хамтлагийн дуучин Ч.Батболд, “Элькондор” хамтлагийн дуучин Д.Жаргалсайхан нар. Мөн л тэр үедээ

уран бүтээлч байлдагч нар эх орноороо аялан тоглолт хийж, соёлыг үрийг тарьж явсан нь нэгтгэлийн түүхэнд тэмдэглэн үлджээ. Харин гурав дахь үедээ буюу 2003 оноос хамтлагийг сэргээж уран бүтээл хийж байгаа залуус бол ахлах ахлагч Н.Баясгалан болон ахлах ахлагч Е.Дашзэвэг (032), ахлах ахлагч Ш.Мөнхбаяр (Нэгдсэн лаборатори), бэлтгэл ахлагч Б.Баярбаясгалан нар. Тэд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд хамт алба хааж байхдаа цэрэг-эх орны сэдэвт уран бүтээлээр залуу үеэ соён гэгээрүүлэх зорилгоор замнал түүхт хамтлагийг дахин сэргээж, 2003 онд бие даасан тоглолтоо үзэгч олондоо өргөн барьсан авьяаслаг уран бүтээлчид ажээ.

Түүнээс мэргэжил бүхэн сайхан, Та бөмбөрчин болсон сэтгэгдлээ хуваалцаач гэхэд “Хөгжмийн аялгуугаар хүнийг тайвшруулж бас омогшуулж болдог. Цэргийн хөгжимчин бид омогшуулж, бахархах сэтгэлийг түгээхийн төлөө хичээж яваа хүмүүс. Харахад зүгээр л нэг бөмбөр нүдээд байгаа мэт боловч цаана нь асар их хүч хөдөлмөр, ур чадвар авьяас билэг, урлагийн торгон мэдрэмж, тэсвэр тэвчээр байдаг” гэж мэргэжлээрээ бахдав.

Бөмбөртэй холбоотой олон сайхан дурсамж байдгийн нэг нь үзүүлэх тоглолтод бэлтгэж байгаад хагалж, түүнээсээ болж шаналж, уйлж байснаа мартдаггүй гэнэ. Зэвсэгт хүчний “Марш-тусгай бэлтгэл”-

ийн аварга шалгаруулах тэмцээн эхлэх гээд байдаг, бөмбөр байхгүй, хамтрагч нөхдийнх нь хөдөлмөр талаар болчих гээд л. Тэгэхэд нэгтгэлийн захирагч байсан бригадын генерал Л.Онцгойбаяр цэргүүдийнхээ тухай сонсоод шинэ бөмбөр аваад Тавантолгой дахь Сургалтын нэгдсэн төвд хүргэж өгч байсныг нь одоо ч санаж явдаг гэлээ.

Бөмбөрчин учраас найз нөхөд, хамтран зүтгэгч нар нь төрсөн өдрөөр нь бөмбөрийн сувинер бэлэглэх нь түгээмэл байдаг гэнэ. 2021 онд хошууч генерал П.Доржсүрэн АНУ-аас захиалж авчруулсан бөмбөрөө “Урлагийн хүний гарт яваг” гээд бэлэглэж байсныг нь ахлах ахлагч Н.Баясгалан дурсаж яриу. Тэр бас бөмбөрийн чимээгээр цэргийн ёслолын жагсаалд алхаж яваа дайчны алдаг амархан засдаг бөгөөд дагнан хичээллэсэн хүндээ хосгүй хөгжмийн зэмсэг гэж тодорхойлно лээ.

Ахлах ахлагч Н.Баясгалан эхнэр, охины хамт амьдардаг. Гэргий Б.Мөнгөнзул нь Зэвсэгт хүчний 334 дүгээр ангид зэвсгийн нярваар ажиллаж байгаад саяхан тэтгэвэртээ гарсан ахлах ахлагч цолтой бүсгүй бол охин Б.Нандин-Эрдэнэ таван настай. Бяцхан охин нь аавынхаа бөмбөрийг нүдээд суучихдаг болсон тухай тэр аз жаргалтайгаар өгүүлж байлаа.

Ахмад Д.БОЛОР

САПЁРЧИН ДАЙЧДЫН ЗОХИОН БАЙГУУЛСАН "СОЁЛЫН ӨДӨРЛӨГ"-ӨӨР ...



Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр анги 2022-2023 оны сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийхээ дунд явуулж байгаа “Номтой нөхөрлөө” аяны хүрээнд 2 дугаар сарын 03-ны өдөр Налайх дүүргийн Соёлын ордонтой хамтран “Соёлын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж явууллаа. Тус өдөрлөгөөр бие бүрэлдэхүүнд Налайх дүүргийн Соёлын ордны бичиг хэргийн ажилтан С.Энхжаргал “Байгууллагын соёл”, “EQ гэж юу вэ” гэсэн сэдвүүдээр лекц, сургалтыг явуулж, хамт олны санал сэтгэгдэл, хэн нэгэндээ хэлэх сэтгэлийн үгийг сонсох сонирхолтой судалгаа авч, зарим захидлыг уншин танилцуулсан юм.

Мөн Налайх дүүргийн

“Голомт” цогцолбор сургуулийн багш, зохиолч, яруу найрагч Г.Буянтогтох нээлтээ хийгээд “Домоос үүссэн домог” номынхоо талаар зохиолч-уншигчийн уулзалтыг зохион байгуулж явуулав. Нүүдлийн номын сан аялуулж, шинэ номын худалдааг өрнүүлэхийн зэрэгцээ Соёлын ордны уран бүтээлчид урлагийн хэсэгчилсэн тоглолтоо өргөн барьж, тус дүүргийн үндэсний үйлдвэрлэгчид үзэсгэлэн дэлгэсэн нь бие бүрэлдэхүүнд оюуны болон соёлын эрэлт хэрэгцээнд нийцсэн арга хэмжээ болж өндөрлөлөө. Түүнчлэн ЗХЖШ-аас ангийн бие бүрэлдэхүүнд шинэчлэн батлагдсан “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийн талаар мэдээлэл өгч, алба хаагчдын сонирхсон асуултад хариуллаа.



ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛУУД ХЭРЭГЖСЭЭР...



Зэвсэгт хүчний 032 дугаар анги 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу “Тасгийн жигдрэлт” шатны төгсгөлд 30 км-ийн явган маршийг Хужирбулангийн чиглэлд үйлдэв.

Маршийн үед бие бүрэлдэхүүн байгаль, цаг агаарын хүндрүүлсэн нөхцөлд инженерийн бэлтгэл, химийн бэлтгэл, эмнэлгийн бэлтгэл, тактикийн ажиллагаа, буудлагын дасгал боловсруулах гэсэн цэгүүдэд үүргээ амжилттай гүйцэтгэсэн нь цагийн байдлын ямар ч нөхцөлд тавигдсан үүргийг биелүүлэх ёс-суртахуун, сэтгэл зүйн өндөр чадвартай байгааг нотлон харуулсан юм.

Үргэлжлүүлэн “Сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөө”-ний дагуу 1 дүгээр сард төрсөн хугацаат цэргийн алба хаагчдын “Төрсөн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ахлах ахлагч Я.Бямбасүрэн “Дөрвөн настай халиун” дуугаар, дэслэгч Б.Дамдиндорж “Сайхан байж ээ”, “Цасан дээр”, “Ирэх өдрийн мэнд” дуугаар, ХХТР-ын байлдагч Х.Батзориг “Нутгаа зорино” дуугаар тус тус ая дууны мэндчилгээ дэвшүүллээ.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА

